

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хагас жилийн биелэлт

2019.06.25.

№	Зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Хүрэх түвшин, үр дүн /Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр сая.төг/		Биелэлт	Хувь
						2019 он			
						Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв		
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ									
1	Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ.	1	Төсвийн сахилга бат, санхүүгийн хяналтын үр дүнг сайжруулна.	2018 - 2020	-	Төрийн байгууллагууд хэмнэлтийг эрхэмлэн, төсвийн сахилга батыг бэхжүүлсэн байна. Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарын хариуцлага дээшилсэн байна.	-	Засгийн газрын 147 дугаар тогтоол, Улсын их хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын биелэлтыг гаргаж ил тод байдлын самбарт байршуулсан. Төсөвт байгууллагууд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зориулалтын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулж байна. Шинээр үүсэж буй өглөг нь төсвийн хуваарь эхний сард бага хуваарилагдсантай холбоотой. Төсвийн шууд захирагч нарыг санхүүгийн албанаас мэдээлэл арга зүйгээр ханган байнгын хамтран ажиллаж байна.	40
		2	Орон нутгийн хөгжлийн санг иргэдэд ил тод, нээлттэй болгож, зарцуулалтын үр дүнг дээшлүүлнэ.	2018 - 2020	-	Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний саналыг иргэдээр эрэмбэлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	-	2020 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналыг багийн Засаг дарга нар батлагдсан маягтын дагуу 862 өрх буюу сумын нийт өрхийн 80 хувиас авч урьдчилсан жагсаалт бэлтгэн 1, 2-р БИНХ-аар хэлэлцүүлэн Засаг даргын 2019 оны А\16 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	70
2	Бизнесийн таатай орчин бүрдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл,	3	Тусгай зөвшөөрлийг хуулийн хүрээнд хүнд сурталгүй олгож, хяналт шалгалтын давхардлыг багасгана.	2018 - 2020	-	Хуулийн хүрээнд шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг олгоно. Хяналт шалгалтыг цөөрүүлж, зөвлөн туслах үйл ажиллагааг	-	Суманд архины тусгай зөвшөөрөлтэй 8 аж ахуй нэгж, тамхины тусгай зөвшөөрөлтэй 7 ААН, иргэд үйл ажиллагаагаа явуулдагаас 2019 онд тамхины тусгай зөвшөөрлийн хугацааг	70

	үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.				сайжруулахад холбогдох ажилтнуудыг сургалтанд хамруулна.		1 иргэн сунгуулсан байна. Архи тамхины тусгай зөвшөөрөлтэй ААН болон худалдаа үйлчилгээ эрхлэж байгаа иргэдийн үйл ажиллагаанд сумын цагдаагийн хэсэг, аймгийн мэргэжлийн хяналтын газар, ХХААГ-тай хамтран улирал бүр хяналт тавин ажилласан.	
		4	ЖДҮДС, СХС-ийн зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	2018 - 2020	ЖДҮДС СХС	<p>Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийн хүртээмж ийг нэмэгдүүлж чанарыг сайжруулна</p> <p>ЖДҮДС, СХС-ийн зээлийн эргэн төлөлт, ашиглалтанд тавих хяналтыг чанаржуулж сайжруулна.</p> <p>Бий болсон байнгын ажлын байрны тоо - 25 Хуваарийн дагуу эргэн төлөлт – 100 хувь</p>	ЖДҮДС СХС	2019 онд СХС-аас зээл олгох тэргүүлэх чиглэлийг сумын ИТХ-аар батлуулсан. Одоогоор зээл олгогдоогүй байна. Сум хөгжүүлэх сангаас 2011-2016 онуудад зээл авсан 61 зээлдэгчээс одоогоор зээлийн үлдэгдэлтэй 41 иргэн байна. Эдгээр зээлдэгчийн эргэн төлөлт, зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхэд хяналт шалгалт хийхэд 20 иргэн зориулалтынхаа дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. 2019 онд СХС-ийн дансанд 61428000 төгрөг төвлөрүүлэхээс 6-р сарын байдлаар 7374387 төгрөг төвлөрүүлж эргэн төлөлт 12 хувьтай байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ

2.1 Худалдаа ,үйлчилгээний салбар

Худалдаа үйлчилгээний чиглэлээр

3	Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	5	Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.	2018 - 2020	ОНХС	<p>Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын соёл, стандартыг дээшлүүлэх сургалт явуулах, зөвөлгөөн зохион байгуулна. Тусгай зөвшөөрөл тохирлын гэрчилгээтэй болгож шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдийг төрийн худалдан авалтанд оролцуулж эхэлнэ.</p> <p>Орон сууцны техникийн давхрыг засварлан ажлын байраар хангах ажлыг</p>	Хөтөл бөр	<p>Сумын “Элбэг дэлбэг цагаан сар” үзэсгэлэн худалдааг 2019 оны 01-р сарын 23-ны өдөр зохион байгуулж 12 иргэн 12 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож нийт 1760000 төгрөгийн орлого олсон байна. Мөн аймгийн “Цагаан сар-2019” үзэсгэлэн худалдаанд 6 иргэн 5 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож сумын оёдолчин З.Билэгбаяр дэд байр эзэлсэн.</p> <p>Суманд талх нарийн боовны үйл ажиллагаа явуулдаг иргэнд зөвлөгөө өгч ажиллан тохирлын гэрчилгээ, хаяг</p>	70
---	--	---	---	-------------	------	--	-----------	--	----

					судлана.		шошигтой болгон үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.		
2.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбар									
Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр									
4	Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангана.	6	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулах үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжинэ.	2018 - 2020	СХС 45.0	Боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн байна.	СХС 15.0	2019 оны 5-р сарын байдлаар ЖДҮ, СХС-уудын журам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан зээл олголт хийгдээгүй байна.	Үнэлэх боломжгүй
		7	Стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын тоог нэмэгдүүлнэ.	2018 - 2020	СХС 10.0	Шинээр засварласан агуулах, зоорийн тоо-1 Агуулахаас зах зээлд нийлүүлж буй бүтэ эгдэхүүний хэмжээ мах 96.1 тн, төмс, хүнсний ногоо 19.7 тн байна.	СХС 10.0	Суманд төмс, хүнсний ногооны 3, махны 1, ашиглагддаггүй 1 нийт 69,5 тн-ын багтаамжтай 5 зоорь байна. Үүнийг стандартын дагуу ашиглах, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.	Үнэлэх боломжгүй
		8	Мал нядалгааны цех байгуулахад бодлогоор дэмжинэ.	2018 - 2020	АОНХС, ЖДҮДС, СХС	Махыг стандартын дагуу бэлтгэн, зах зээлд нийлүүлж эхэлнэ.	-	Мал нядалгааны стандартын шаардлага хангасан 1 цэгтэй болох зорилгоор газрын байршлыг эрчимжсэн МАА-н бүсэд гаргахаар газрын асуудлыг шийдвэрлэж зориулалтын бус газар мах нядалгааны цэг ажиллуулж байгаа иргэнийг нүүлгэн шилжүүлэх үүрэг өгсөн боловч цахилгааны шугам тавигдаагүй учир үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байна гээд нүүгээгүй болно. Уг цех нь сумын иргэдийн махны хэрэгцээний 80 хувийг ханган ажиллаж байна.	40
		9	Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээнд тавих хяналтыг сайжруулна.	2018 - 2020		Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувь Хүнсний бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлын хяналт сайжирна	-	Суманд хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээ явуулдаг дэлгүүр, лангуунууд болон архи, тамхины тусгай зөвшөөрөлтэй 29 аж ахуй нэгж байгууллагуудад 1-р улирлын хяналт шалгалтыг зохион байгуулж заавар зөвлөгөө өгч ажилласан. 1 дэргүүрийн тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрийн хугацаа дууссаныг хураан авч сунгуулах үүрэг өгч ажилласан.	40
Мал аж ахуйн чиглэлээр									

5	Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалж, үүлдэр, угсааг сайжруулж, ашиг шимийг дээшлүүлнэ.	1 0	Мал үржлийн нэгжийг бий болгон, өндөр ашиг шимт малыг бүртгэлжүүлж, гарал үүслийг тодорхой болгоно.	2018 - 2020	ОНХС 2.4	Цөм сүргийн болон бог малын нийт хээлтүүлэгч малыг ангилалт, баталгаажуулалтанд 100% хамруулж, хээлтэгч малын 12% -ийг ээмэгжүүлэн, ангилалт, баталгаажуулалт хийсэн байна.	ОНХС 0.8.	Малын хээлтүүлэгчийг эх сүргээс нь ялган суурилуулах ажлыг зохион байгуулж 36 хуц, 31 ухна ялган суурьшуулж ангилалт, баталгаажуулалт, ээмэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	70
		1 1	Ямааг ноолуур, махны чиглэлээр, хонь, үхрийг махны чиглэлээр үржүүлж, ашиг шимийг дээшлүүлнэ.	2018 - 2020	ОНХС 7.2	Малчдад гэрээгээр ашиглуулж, үр төлд нь ангилалт баталгаажуулалт хийж, ээмэгжүүлэн цахим санд бүртгэж ашиг шимийн бүртгэл хөтөлж эхэлнэ.	ОНХС 6.2	“Малын үүлдэр угсааг сайжруулах”-аар 2018 онд махны чиглэлийн Керей үүлдэрийн 1 хуц, торгууд үүлдэрийн 1 хуц, керей үүлдэрийн 6 хурган хуц, ноолуурын чиглэлийн 4 ухна худалдан авч энэ намраас малчдын малын хээлтүүлгийг сайжруулах ажлыг зохион байгуулна. Мөн сумын 3 малчин өрх залаа жинстийн цагаан ухнаар ямаан сүргийн үүлдэр угсааг сайжруулсан.	40
		1 2	Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.	2018 - 2020	УТХО 18.0 ОНХС 26.0	Засварлах худаг -2 5000 га-д хортон мэрэгчидтэй тэмцэнэ. 2 га талбайд олон наст ургамал тарьж бэлчээрийг өтгөрүүлнэ.	ОНХС 10.0 ОНХС 0.7 ОНХС 3.0	Бэлчээрийн менежментийн 2019 оны төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумын нутаг дэвсгэр дээрхи хаврын улирлын бэлчээрт даац тогтоолт хийхэд бэлчээрийн даац хүрэлцэхгүй байна. Суманд бэлчээрийн даац хүрэлцэхгүй байгаа тул малчдын 14 хувь нь Далан жаргалан, Баянжаргалан, Говь-Угтаал сумын нутагт отор хийхээр нүүгээд байна. Бэлчээрийн бүтцийг сайжруулах зорилгоор олон наст ургамал тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэн хаялга орчимд малын тэжээлийн ургамал болох шар царгас шинээр 1 га-д тариалахаар хөрсний боловсруулалт хийгээд байна.	40
		1	Хадлангийн тоног	2018	ОНХС	Хадлангийн тоног төхөөрөмж	ОНХС	Хадлангийн тоног төхөөрөмж	Үнэлэ

		3	төхөөрөмжийн хувийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах	- 2020	20.0	шинээр худалдан авч малчдад гэрээгээр ашиглуулна.	20.0	худалдан авах ажлыг 2020 оны улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад оруулж, саналыг ИТХ-д өгөхөөр бэлтгээд байна.	х болом жгүй.
		1 4	Малжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2018 - 2020	-	Ган, зуд гамшгийн эрсдэлд өртсөн, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой малчин өрхийг малжуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Шинээр малжиж байгаа мал бүхий иргэдийг сургалтанд хамруулж, туршлага судлуулж, сайн туршлагад хамруулна.	-	“Иргэдийг малжуулах журам”-ын дагуу цөөн мал бүхий 4 малчин өрхөд тус бүр 40 хонь, 20 ямаа нийт 240 толгой малыг 10 сар хүртэл 1 жилийн хугацаатай гэрээгээр хүлээлгэн өгч үр төлийг нь малчдад үлдээж малжуулах ажлыг зохион байгуулж байна. “Тэгш дүүрэн” хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 3 өрхийг хамруулж өрх бүрт 32 толгой ямааг 2019 оны 10 сар хүртэл гэрээгээр хүлээлгэн өгч малжуулах ажлыг зохион байгуулсан.	100
		1 5	Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, бодлогоор дэмжиж, гахай, шувууны аж ахуйн тоог нэмэгдүүлнэ.	2018 - 2020	ЖДҮ СХС 10.5	Гахай, тахиан аж ахуйг дэмжиж, ашиг шимийг нэмэгдүүлэхэд 1 иргэнд зээлийн дэмжлэг үзүүлнэ.	СХС 3.5	Сумын хэмжээнд гахайн аж ахуй эрхлэгч-2 иргэн, тахиан аж ахуй эрхлэгч-2 иргэн 30 гахай, 17 тахиаг өсгөн үржүүлж байна. Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутагт гахай, шувууны аж ахуй эрхэлдэг 5 өрхөд нийт 1,25 га газрыг эзэмшүүлэн олгосон ч цахилгааны асуудал шийдвэрлэгдээгүй учир нууж суурьшсан иргэн байхгүй байна.	40
6	Мал эмнэлэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж малын халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлнэ.	1 6	Мал, амьтныг ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн дагуу хэрэгжүүлнэ.	2018 - 2020	ОНТ 4.8 ОНХС 9.6	Ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал, амьтныг хамруулна.	ОНХС 4.8	Ужиг халдварт өвчний вакциныг эпизоотлогийн дагуу технологит хугацаанд нь чанартай хийлгэсэн. 2020 оны мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, ажил үйлчилгээний хөлсийг ИТХТ-ийн 2019 оны 41 дүгээр тогтоолоор батлуулсан. “ДЭОР” Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээг 2019 оны 03 сард байгуулан хаврын вакцинжуулалтын ажлыг хийж шөвөг яр, боом өвчнөөс урьдчилан	70

							сэргийлэх вакцинд 4190 толгой мал хамрагдсан байна.		
		1 7	Шинээр гарч байгаа халдварт өвчний тандалт судалгааг хийнэ.	2018 - 2020	ОНТ 3.0 ОНХС 6.0	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран шинээр гарч байгаа халдварт өвчний тандалт, судалгаа хийгдсэн байна.	ОНХС 3.0	Аймгийн мал эмнэлгийн газрын лаборатортой хамтран ажиллах гэрээ байгуулан тандалт судалгааг төлөвлөсөн хугацаа болоогүй байна. 7-9 саруудад хийгдэнэ.	Үнэлэх боломжгүй
		1 8	Мал эмнэлэгийн нэгжүүдийн дэмжиж, малын эм тарианы зохистой хэрэглээг нэвтрүүлж хяналт тавина.	2018 - 2020		Малын эм тарианы хэрэглээний талаар малчдад сургалт зохион байгуулна. Хүнсний зах, дэлгүүр, гар дээрээс борлуулагдаж байгаа малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах эмийн үлдэгдлийг тодорхойлж хяналт тавих ажлыг сайжруулан хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартыг хангуулна.		Малын эм тарианы хэрэглээний талаар малчид мал бүхий иргэдэд 2 удаа сургалт зохион байгуулж 155 иргэн хамрагдсан байна. Мөн хөдөөгийн багийн 35 өрхөд “Малын эмийн зохистой хэрэглээ” гарын авлагыг хүргэсэн. Мөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд хяналт шалгалтыг нэг удаа хийсэн. Хүнсний зах, дэлгүүр, гар дээрээс борлуулагдаж байгаа малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд РН тодорхойлж гарал үүсэлийн бичгийг тн маханд олгосон байна.	70
Газар тариалангийн чиглэлээр									
7	Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	1 9	Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, нэгж га-аас авах ургацыг нэмэгдүүлнэ.	2018 - 2020	ХЭДС, СХС 5.0	Төмс, хүнсний ногооны үрлүүр, хураагч, хүнсний ногооны үрсэлгээ суулгагч тус бүр 1-ийг авсан байна. Үйлчилгээ үзүүлэх талбай 5 га Эргэлтийн талбайг 11.64 га-д хүргэн талбайн ашиглалтыг 80цн/га-аас доошгүй хувьтай байлгана.	СХС 5.0 ХЭДС,	ХХААГ-тай хамтран газар тариалан эрхлэгчдэд сургалт зохион байгуулж 16 иргэнийг хамруулан зөвлөгөө зааварчилгаа өгч сонгино, хүрэн манжин, лууван, хүлэмжийн помидор зэрэг хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй олгосон. Сумын 4 иргэн, 2 байгууллага 4 га – д тариалалт хийхээр хөрсний боловсруулалт хийж бэлтгэл ажлыг ханган үрсэлгээгээ хийгээд байна. Сумын 1-р багийн 2 иргэнд 4 га атар болон атаршсан талбайг эргэлтэнд оруулахаар эзэмшүүлэх гэрээг байгуулаад байна.	40
		2 0	Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, ургацыг нэмэгдүүлнэ.	2018 - 2020	СХС 15.0	Шинээр 120 м2 талбай бүхий зуны хүлэмж худалдан авч ашиглалтанд орсон байна	СХС 5.0	Аймгийн ХХААГ-тай хамтран хүлэмжинд ногоо тариалах, хүнсний ногоог хэрхэн арчлах сэдэвт сургалтанд газар тариалан эрхэлдэг	

							16 иргэнийг хамруулсан. Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэхээр 32м ² талбайд зуны хүлэмж шинээр ашиглалтанд оруулж тариалалтаа хийгээд байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэнийг хамруулан 120м ² - тай хүлэмжинд шинээр хүнсний ногоо тариалаад байна.	70
	2 1	Чацаргана болон бусад жимс, жимсгэнэ тариалахыг дэмжинэ.	2018 - 2020	ХХО 4.3	Шинээр тариалах талбай 0.1 га-д чацаргана болон бусад жимс, жимсгэнэ 0.1 га-д тариалж, бойжилт 50 хувь байна.	ХХО 1.4	Сумын 1-р багийн иргэн 1га газарт чацаргана тариалаад байна. Мөн 10 иргэн 2 байгууллага 3 төрлийн жимсний мод тариалж байна.	40

Хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр

8	Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2 2	“Итгэлийн зээл” олгож, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.	2018 - 2020	ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулах орчин нөхцлийг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана Зээлийн болон газрын бодлогоор дэмжсэн байна.	ЖДҮДС	Аймгийн ХХҮГ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 иргэн блок үйлдвэрлэх, буриад гутал үйлдвэрлэх чиглэлүүдээр 7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.	40
		2 3	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, борлуулалтыг дэмжинэ.	2018 - 2020	-	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний сав баглаа боодлыг стандарт хэмжээнд хүргэнэ. Үзэсгэлэн худалдааг уламжлал болгон зохион байгуулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилна.	Хөтөл бөр	Суманд талх нарийн боовны үйл ажиллагаа явуулдаг иргэнд зөвлөгөө өгч ажиллан тохирлын гэрчилгээ, хаяг шошигтой болгон үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Сумын “Элбэг дэлбэг цагаан сар” үзэсгэлэн худалдааг 2019 оны 01-р сарын 23-ны өдөр зохион байгуулж 12 иргэн 12 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож нийт 1760000 төгрөгийн орлого олсон байна. Аймгийн “Цагаан сар-2019” үзэсгэлэн худалдаанд 6 иргэн 5 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож сумын оёдолчин З.Билэгбаяр дэд байр эзэлсэн.	70

2.3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар

2.4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбар

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр

9	Газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, газар олголтыг эрчимжүүлнэ.	2 4	Иргэнд газар өмчлүүлэх ажлыг хуулийн хугацаанд хэрэгжүүлнэ.	2018 - 2020	-	Нийт иргэдийг газар өмчилж авах боломжоор хангасан байна.	-	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 09 дугаар тогтоолоор сумын 2019 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн 80 иргэнд өвөлжөө хаваржаа, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 6,15 га газрыг өмчлүүлэхээр батлуулан газар олголтын ажлыг зохион байгуулж байна.	70
		2 5	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулна.	2018 -- 2020	-	ГЗБ-ын төлөвлөгөөний дагуу газар олголтыг зохион байгуулж газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.	-	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 09 дугаар тогтоолоор сумын 2019 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулсан.	100
		2 6	Сумын төвийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулна.	2018 - 2020	ОНХС 10.0	Орон нутгийн шаардлагатай газруудын оноосон нэрийг судлан, баталгаажуулах ажлыг зохион байгуулна. Хаягжуулалтыг үргэлжлүүлэн хийнэ.	ОНХС 5.0	Сумын төвийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах ажлыг 2018 оны ОНХС-ийн 4,8 сая төгрөгийн хөрөнгөөр "Их эффект" ХХК-тай гэрээ байгуулан сумын төвийн орон сууцны 22 хаяг, орцны 53 хаяг, Объектын байрлал заасан 1 хаяг, байшин барилгын-33 хаяг нийт 108 ширхэг хаягийг хийж байршуулан сумын төв гудамжийг "Уурхайчдын өргөн чөлөө" хэмээн нэрлэсэн.	100
		2 7	Газрын биржийн цахим системийг нэвтрүүлнэ.	2018 - 2020	-	Газрын биржийн цахим системийг нэвтрүүлж, иргэдэд үйлчилнэ.	-	2 иргэний газар эзэмших эрхийн барьцаалбарыг газрын цахим биржд бүртгэн баталгаажуулсан. Иргэн ААНБ-д Газрын цахим биржийн талаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.	40
		2 8	Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлана.	2018 - 2020	ОНТ	Иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил, өмчлөл, ашиглалтын газрын эрхийн гэрчилгээг шинэчлэх, солих ажлыг 20%-д хүргэнэ.		Иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил, өмчлөл, ашиглалтын газрын эрхийн гэрчилгээг шинэчлэх, солих ажлыг зохион байгуулж байна. 6-р сарын байдлаар зөрчилтэй	40

							солигдсон гэрээ, гэрчилгээ байхгүй болно.	
		2 9	2018 - 2020	-	Лэнд менежер программ хангамжийг нэвтрүүлсэн байна.	-	Лэнд менежер программ хангамжийг 2017 онд нэвтрүүлэн газар өмчлөл эзэмшлийн бүх мэдээллүүдийг цахимжуулан ажиллаж байна.	70
10	Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна.	3 0	2018 - 2020	УТХО 200.0 ОНХС 10.0	Суманд байгуулах цэвэрлэх байгууламжийн хөрөнгийг шийдвэрлүүлнэ	-	Цэвэрлэх байгууламжийн зураг төсвийг хийлгэх санхүүгийн асуудлыг 2019 оны ОНХС-ийн 15,9 сая төгрөгийн хөрөнгөөр хийлгэхээр зөвлөхийн хураангуй жагсаалтад бүртгэлтэй 3 байгууллагад тендерийн баримт бичгийг хүргүүлэн нийтэлсэн.	40
		3 1	2018 - 2020	СОНХС 6.0	Иргэдийн идэвхи, санаачлага нэмэгдэж орцны дотор, гадна засвар, тохижилтын ажлууд жишиг болон хийгдэнэ.	ОНХС 3.0	Орон сууцны байрнуудын дунд “Цэвэр орчин бидний гэр” 1 сарын аяныг зохион байгуулж цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Бүх нийтийн их цэвэрлэгээг сар бүр зохион байгуулж байна.	40
		3 2	2018 - 2020	ОНХС 150.0	Сумын айл өрхүүд АБ, ААН-үүдийн хог хаягдлыг тээвэрлэх төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах, хогийг цэвэрлэх булаах ажлыг үргэлжлүүлнэ. Хог хаягдал ангилан ялгах дахин боловсруулах цех байгуулахыг бодлогоор дэмжинэ. Хог тээврийн 1 авто машин худалдан авна.	СОНХС С 20.0 - ОНХС 70.0	Улсын төсвийн 13 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдлыг тээвэрлэх ажлыг 2-р багийн 2 иргэнтэй гэрээ байгуулж хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тогтмол тээвэрлэн хүргэж байна. Нийтийн орон сууцнуудын гадна шинээр 2 хогийн бункер нэмэгдүүлэхээр гэрээг байгуулан гүйцэтгүүлж байна. Албан байгууллага, ААН-үүдэд сар бүр хог хаяглын төлбөрийн нэхэмжлэх тарааж хог хаягдал гаргасны төлбөрийг орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажиллаж байна. 06 сарын байдлаар орон нутгийн орлогод хог хаягдлын хураамж 6145900 төгрөгийг төвлөрүүлээд байна.	70
		3 3	2018 - -	ОНХС 100.0	Урд гэр хорооллын ус түгээх цэгийг цахимжуулж байрны	СОНХС С	2019 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын нэгдсэн	Үнэлэх

			засварлан, ус түгээх авто машинаар хангана.	2020		засвар хийж орчныг тохижуулна.	10.0	жагсаалтад уг ажлыг тусгасан боловч батлагдаагүй болно.	болом жгүй
Эрчим хүчний чиглэлээр									
11	Цахил гаан, дулааны эрчим хүчний хангамжийг нэмэг дүүлж, хэвийн үйл ажилла гаг хангана.	3 4	Сумын төвд иргэдийн өмчлөлд шинээр олгосон газруудын цахилгаан хангамжийг шийдвэрлэнэ.	2018 - 2020	ОНХС 70.0	Иргэдийн өмчлөлд олгогдсон газарт цахилгаан татах ажлыг эхлүүлнэ.	СОНХ С 35.0	2020 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын нэгдсэн жагсаалтад иргэдийн өмчлөлд шинээр олгосон газруудад цахилгаан татах саналыг тусгаад байна.	Үнэлэ х болом жгүй
Зам тээврийн чиглэлээр									
12	Орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөтгөж, засварлана.	3 5	Ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвд авто зам тавьж, авто замын сүлжээг өргөтгөнө.	2018 - 2020	АОНХС 1400.0 УТХО 3500.0 СОНХС 16.0	Суманд 2 км авто зам шинээр тавина. Сумын төвийг босоо тэнхлэгийн авто замтай холбох ажлын зураг төсвийг боловсруулна.	АОНХ С 1400,0 ОНХС 10.0	ОНХС-ийн 19,5 сая төгрөгийн хөрөнгөөр сум дотор хатуу хучилттай засмал зам тавих зураг төсвийг хийлгэхээр тендер зарлагдаад байна.	40
		3 6	Сумын нийтийн эзэмшлийн талбайд явган зам, зогсоол, гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлнэ.	2018 - 2020	ОНХС 136.0	Сумын 1дүгээр багийн ногоон байгууламжийн орчимд нийтийн тээврийн авто зогсоол байгуулна. Сумын нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээг үргэлжлүүлэн хийнэ.	ОНХС 50.0 ОНХС 2.0	ОНХС-ийн 15 сая төгрөгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээг хийлгэхээр ажлын даалгаврыг боловсруулаад байна.	40
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО									
3.1. Эрүүл мэндийн салбар									
13	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3 7	Сумын эрүүл мэндийн төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2018 - 2020	ОНХС 110.0	Эрүүл мэндийн төвийг цус, шээсний анализатораар хангана.	ОНХС 40.0	1. Сумын эрүүл мэндийн төвд үзлэг шинжилгээний мобайл технологийн 7 төрлийн багаж хэрэгслийн багцыг Эрүүл мэндийн яамны 23,6 сая төгрөгийн санхүүжилтээр хүлээн авч иргэдэд үйлчилж байна. Тус багц төхөөрөмжөөр эхо оношилгоо, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, элэгний В, С, ходоодны хеликобактерийн илрүүлэг, холестрин, цусан дахь сахарын	100

						хэмжээг тодорхойлох гэх мэт. Мөн Эрүүл мэндийн төв нь өөрсдийн нөөц хөрөнгөөр Эмнэлгийн тусламж үйлчилгээнд Сувилахуйн тэргэнцэр 2ш, Парাপин хайлуулагч, Автоклав, лаа, зажим 10ш нийт 5 төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг 1,048,000 төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан.	
38	Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж ийг нэмэгдүүлж, нялхсын эндэгдлийг бууруулна.	2018 - 2020	ОНХС 35.0	Сумын эрүүл мэндийн төвийг нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнд шаардлагатай хүүхдийн сэхээн амьдруулах тоног төхөөрөмжөөр хангана. Иргэдэд зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулна.	ОНХС 35.0	Сумын эрүүл мэндийн төв нь эх нярайн хяналтыг сайжруулж төрсний дараах хяналтын үзлэгийг шинээр төрсөн эх, нярайд 7 хоног бүр хийж, товлотт вакцинжуулалтанд хамруулж ажилласнаар нялхсын эндэгдэл гараагүй болно. 2019 оны 6 сарын байдлаар 63 эмэгтэйг жирэмсний эрт хяналтанд авсан байна.	40
39	Зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулна.	2018 - 2020	ОНХС	Эрүүл мэндийн төвийг зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. Эрт илрүүлгийн үзлэгийн хувь: Вируст гепатит - 40%, сүрьеэ - 20%, БЗДХ/ХДХВ - 25%, хөхний хавдар-65%, умайн хүзүүний хавдар-70%	С ОНХС	Хүн амын дунд цусны даралт ихдэлт, чихрийн шинжин, хөх умайн хүзүү, элэгний хорт хавдар болон гепатитын В, С вирусын халдвар, сүрьеэгийн өвчлөл тархалтыг бууруулах зорилгоор эрт илрүүлгийг хийж байна. 2019 оны 05 дугаар сарын байдлаар цусны даралт ихдэлт-224 буюу 28.5% , чихрийн шинжин -224 буюу 28.5% , хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэг-13%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг – 9%-ийг хамруулаад байна. “Элэг бүтэн монгол” 3 хөтөлбөрийн хүрээнд зорилтот насны 168 иргэн хамрагдахаас 75 иргэн хамрагдсан байна. Уг хамрагдсан иргэдээс 2 иргэн В, 2 иргэн С, 1 иргэн эргэлзээтэй байгаа шинжилгээнүүдийг вирусын ачаалал тоолуулахаар аймгийн нэгдсэн эмнэлэгт илгээсэн. Бэлгийн замын халдварт өвчний шинжилгээнд 130 иргэнийг хамруулж	70

								шинээр илэрсэн бэлгийн замын халдварт өвчний 15 дохиолдолыг аймгийн нэгдсэн эмнэлэгт баталгаажуулах шинжилгээнд хүргүүлсэнээр 10 иргэнд хянан эмчилгээ эхлээд байна.	
3.2. Боловсрол, соёл урлаг, спортын салбар									
Боловсролын чиглэлээр									
14		40	Сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2018 - 2020	УТХО 6.424.0 ОНХС 2.0	Сумын 3-р сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын ажлын хөрөнгийг шийдвэрлүүлнэ.	УТХО 4724.0	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт улсын төсвийн 4,7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Шивээговь сумын 3-р сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөгдсөн байна.	Үнэлэх боломжгүй
		41	Сургууль цэцэрлэгийн орчинг тохижуулна.	2018 - 2020	УТХО 200.0 ОНХС 11.0	3-р цэцэрлэгийн их засварын ажлыг гүйцэтгэнэ.	УТХО 200.0	3-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв хийлгэх ажлыг 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн Зөвлөх үйлчилгээний ажилд тусгуулахаар иргэдээс санал авч, эрэмбэлүүлсэн	Үнэлэх боломжгүй
		42	Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангана.	2018 - 2020	ОНХС 42.0	Сургууль цэцэрлэгүүдийн номын санг тохижуулж, номын фондыг баяжуулна.	С ОНХС 2.0	“Боловсролын чанарын шинчлэл” төслийн хүрээнд дэлхийн банкны 8,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 139 нэр төрлийн 493 ширхэг бага ангийн номын тоог нэмэгдүүлсэн. 3-р цэцэрлэг нь 2018 онд төсөлт тоглоом, стем хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллан 9 бүлгийг 280 ширхэг номоор хангасан.	70
Соёл урлаг, спортын чиглэлээр									
15	Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.	43	Соёл, урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2018 - 2020	ОНХС 5.5	Цахим номын санг тохижуулж фондыг нэмэгдүүлнэ.	ОНХС 1.0	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 нэр төрлийн 92 ширхэг номыг худалдан авч сумын нийтийн номын сангийн фондыг нэмэгдүүлсэн.	100
		44	Боржигин өв соёл, уртын дуу, морин хуурын сургалт, сурталчилгааг эрчимжүүлнэ.	2018 - 2020	ОНХС 3.0	Боржигин морин хуур, боржигин уртын дууны сургалтыг зохион байгуулна. Боржигин морин хуураар хангана. Боржигин уртын дуу,	ОНХС 2.5	Аймгийн Боловсрол соёл урлагийн газартай хамтран Боржигин морин хуурын сургалтыг 35 сурагчид долоо хоногийн Баасан гараг бүр зохион байгуулахаар 2019 оны 04 сард гэрээ	

						морин хуурын тайлан тоглолтод оролцоно.		байгуулан ажиллаж байна. Боржигон уртын дууны сургалтанд хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэж байна. Аймгийн Боржигон чуулгаас 3-р сургуульд 7 морин хуур олгосон.	70
16	Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.	4 5	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2018 - 2020	ОНХС	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	ОНХС	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 1 зорилтын хүрээнд 7 ажлыг хийхээр төлөвлөж, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн дагуу суманд нийт мэргэжлийн багш дасгалжуулагч 3, спортын зэрэг цолтой 3 иргэн 5 төрлийн дугуйлан, секц хичээллүүлж, хүн амын 8 хувь буюу 286 иргэн /"Хаялга" спорт клубт 146 сурагч, 100 буудалт даам, шатрын дугуйланд 40 сурагч, ХС спиннинг клубт 60 иргэн, иог дасгалын анхан шатны курст суралцсан 40 иргэн/ тогтмол дасгал хөдөлгөөнөөр хичээллэж, ажлын байрны дасгал хөдөлгөөнөөр сумын Эрүүл мэндийн төвийн 20 ажилтан хичээллэж байна. Биеийн тамираар тогтмол хичээллэгсэд нийт хүн амын 5.5%, дунд зэргийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсэд нийт хүн амын 2.9%-ийг эзэлж байна. "Хаялга" спорт клубын тамирчид бүс улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанаас нийт 11 алт, 9 мөнгө, 22 хүрэл медаль тус тус хүртсэн байна. Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 72 иргэн буюу хүн амын 2%-ийг хамруулсан байна. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилт 45 хувийн хэрэгжилттэй байна.	40
		4 6		2018 - 2020	СОНХС 20.0	Чөлөөт бөхийн стандартын дэвжээтэй болно.	ОНХС 15.0	2019 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын нэгдсэн жагсаалтад уг ажлыг тусгасан боловч батлагдаагүй болно.	Үнэлэх боломжгүй
3.3. Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбар									

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр

17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулна.	4 7	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлж ажилгүйдлийг бууруулна.	2018 - 2020	ХЭДС	Байнгын ажлын байранд 70, түр ажлын байранд 50-аас доошгүй иргэнийг хамруулсан байна.	ХЭДС	2019 оны 5-р сарын 25-ны өдрийн байдлаар Сумын ИТХ-1, Засаг даргын тамгын газар -2, Илчлэг Шивээ ОНӨҮГ- 2, Шивээ-Овоо ХК -27, Ерөнхий боловсролын сургууль-2, Эрүүл мэндийн төвд-3, цэцэрлэг-3, Монголын алт МАК ХХК-3, нийтийг хамарсан ажил-5 нийт 48 сул чөлөөтэй орон тооны захиалгыг авч мэдээллийн санд бүртгэж, 33 иргэнийг байнгын, 14 иргэнийг түр ажлын байранд зуучилсан.	40
18	Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэн, ядуурлыг бууруулна.	4 8	Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2018 - 2020	ОНХС	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамруулах, ажлын чиг баримжаа олгох, хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулж, нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	ОНХС	Зорилтод өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдах 16 өрхийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 26 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Уг өрхүүдэд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг зохион байгуулан үнэлгээг хийгээд байна. 3. 2019 оны 1-р сарын 29-ний өдөр сумын Эрүүл мэндийн төв, Аймгийн эрүүл мэндийн газар хамтран зохион байгуулсан “Иргэн төвтэй – Эрүүл мэнд” өдөрлөгт зорилтод бүлгийн 28 иргэн, 32 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндийн зөвлөгөөг өгсөн. Үүнд: Элэгний В, С вирусын шинжилгээ, Цусны дэлгэрэнгүй шинжилгээ, Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ, Дотор эрхтний үзлэг, Эхо, Чих хамар хоолой, Нүд, Мэдрэл Зорилтод өрхийн 8 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол, 19 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж боловсролын зохих түвшний сургалтанд хамруулсан.	70

							<p>Ажилгүй 19 иргэнгээс 5 иргэнийг байнгын ажлын байранд 1 иргэнийг түр ажлын байранд зуучилж орлоготой болгосон.</p> <p>Зорилтод бүлгийн иргэдээс 60 иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулан 10935000 төгрөгийн тусламж, дэмжлэгийг олгосон.</p> <p>Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан 2019 оны 05-р сард сумын Засаг даргын Тамгын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран “ГЭР БҮЛИЙН АЗ ЖАРГАЛ ӨДӨРЛӨГ”-ийг зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд илтгэгч Б.Төмөртоогоо “Гэр бүлийн үнэ цэнэ” лекцийг тавьж, зорилтот бүлгийн 16 өрхийн төлөөллийг хамруулсан.</p> <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 2019 оны 04-р сард Хөдөлмөрийн өдөрлөг” арга хэмжээг Шивээговь суманд зохион байгуулан зорилтод бүлгийн 16 өрхийн төлөөлөл болох 22 иргэнийг хамруулсан.</p>	
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр								
19	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	4 9	Гэр бүл, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлнэ.	2018 - 2020	ОНХС	Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулж идэвхижүүлнэ. . Холбогдох хуулийг иргэдэд сурталчилна	<p>Сумын гэр бүл, хүүхэд хамгааллын Хамтарсан багийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг төлөвлөсөн.</p> <p>Сумын гэр бүл, хүүхэд хамгааллын Хамтарсан багийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу хүчилхийлэлд өртөж болзошгүй 10 хүүхэд, бүтэн өнчин 3, хагас өнчин 48 хүүхдийн судалгааг нэгтгэж гаргасан. Мөн “Гэр бүлийн баяр хөөр” сургалтыг 20 эцэг эхчүүдэд зохион байгуулж, хүүхдийн тусламжийн 108 дугаарт ирүүлсэн 2 кейс, өмнөх онд нээсэн 3</p>	70

							кейс дээр үргэлжлүүлэн ажиллаж байна.			
		50	“Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2018 - 2020	ОНХС	“Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	ОНХС	Хөтөлбөрийн хүрээнд 12 ажлыг 6.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 9 ажлыг 2,479,200 төгрөгөөр хийж гүйцэтгэж, эхний хагас жилийн байдлаар хугацаа хоцорсон ажил байхгүй болно.	70	
		51	Зорилтот бүлгийн гишүүдийг хөнгөлөлттэй үнээр тээвэрлэх, нийтийн тээврийн бодлогыг хэрэгжүүлнэ.	2018 - 2020	ОНХС 2.0	Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үнээр тээвэрлэхэд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлж үйл ажиллагааг эхлүүлсэн байна.	ОНХС 1.0	Санхүүгийн эх үүсвэргүй учир хэрэгжих боломжгүй.	Үнэлэх боломжгүй	
Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого										
4.1. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн чиглэлээр										
20		52	Хуримтлагдсан хур хог, хаягдал, туурь балгасыг цэвэрлэж нөхөн сэргээнэ.	2018 - 2020	ОНХС 40.0	Цэвэрлэх туурь балгас, хур хог хаягдал бүхий талбайн хэмжээ - 2 га	ОНХС 20.0	Сумын зүүн болон урд гэр байруудад олон жил хуримтлагдсан 5 га талбайн 120 м3 хур хог хаягдлыг цэвэрлэж, 40м3 орчмыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн, үлдсэнийг булж тэгшлүүлсэн.	100	
4.2. Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль хамгаалах ажилд бүх нийтийн оролцоог хангах чиглэлээр										
21	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, зохистой ашиглана.	53	Булаг, шанд, рашааны эхийг хамгаална.	2018 - 2020	АБХНСА	Тооллогын ажлыг зохион байгуулж, мэдээллийн санг шинэчилнэ. Булаг шандны хамгаалалтыг сайжруулсан байна.	БХНС АХЗ 3.0	Нэртийн булаг, Бэхтийн булаг, хаялга нуурын орчны хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг нийт 4 удаа зохион байгуулж 23 байгууллагын 141 ажилтан албан хаагчид хамрагдаж 84м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. “Нэртийн булаг”-ыг эхийг хамгаалсан хашааг ОНХС-ийн 200000 төгрөгийн хөрөнгөөр сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.	70	
		54	Сумдын ундны усны эх үүсвэрийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч, хамгаалалтын горимыг мөрдүүлнэ.	2018 - 2020	АБХНСА	Сумын ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн дэглэм мөрдүүлнэ.	АБХН САХЗ 3.0	Сумын ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн дэглэмийг мөрдүүлэн ажиллаж байна. Улирал бүр ундны усыг итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж, үр дүнд тохирсон арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна.	70	
22	Байгаль	5	Иргэдийн экологийн	2018	АБХНСА	Байгаль орчны хууль	АБХН	Эргүүл шалгалтын үеэр 2-р багийн 8		

	орчныг хамгаалж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ашиглалтыг сайжруулахад олон нийтийн оролцоог хангана.	5	боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	- 2020		тогтоомжуудыг сурталчлан байгаль хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	САХЗ 5.0	малчид иргэдэд Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Зөрчлийн тухай хуулиуд болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар гарын авлага тараан, зөвлөмж мэдээллийг өгсөн. Мөн 03 сарын 01-нд зохион байгуулагдсан Малчдын зөвлөгөөний үеэр малчид иргэдэд байгаль хамгаалах малчдын нөхөрлөл, бүлэгтэй болох уриалгыг гаргасан. Хаврын мод тарилтын үеэр байгууллагуудаас гадна 38 иргэнээс 70 ширхэг модны тарьц, суулгацын захиалгыг хүлээн авч, тараасан ба иргэд өөрсдийн эзэмшлийн газар, хашаандаа мод, зүлэг, мандлын цэцэгс тарьсан. Мөн нэртийн булгийн хашааг сэргээн засварлах ажлыг малчдын бүлэгтэй хамтран зохион байгуулсан.	70
23	Ногоон бүс, ойн зурвас байгуулан газрын хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна.	5 6	Сумын төвд ногоон байгууламжийн бичил цэцэрлэг байгуулна.	2018 - 2020	ОНХС 12.9	Сумын төвийн зам дагуу таригдсан мод болон нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг сайжруулна.	ОНХС 2.0	“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг 5 дугаар сарын 15-22-ны хооронд зохион байгуулж 17 аж ахуйн нэгж, байгууллага 9 иргэн сумын төвийн цэцэрлэг хүрээлэн болон өөрийн эзэмшлийн талбайд 8 төрлийн 1301 ширхэг мод шинээр тарьсанаас цэцэрлэгт хүрээлэнд нөхөн сэргээлт хийж 106 мод тарьсан. ОНХС-ийн 3,3 сая төгрөгийн хөрөнгөөр Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааны ажлыг 1-р багийн иргэнтэй гэрээ байгуулан хийлгэж байна.	70
24		5 7	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ.	2018 - 2020	АБХНСА ХЗ	Эргүүл шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулж зөрчлийг арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	АБХН САХЗ	Хориотой ан, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэж байгаа байдал, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхэд цаг үеийн шинжтэй болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх эргүүл	

							шалгалтаар 05 сарын 08, 20-ны өдрүүдэд сумын 2-р багийн хөдөөгийн нутаг дэвсгэрээр 250 орчим км явж, хөдөөгийн малчин 8 айлд байгаль орчны талаарх хууль тогтоомжуудын гарын авлага, тараах материалыг өгсөн. Зүйтийн тал орчимд 20 орчим цагаан зээр тогтуун идээшилсэн байдалтай байсан. Малчид иргэд Страто ХХК-ийн зам тавих ажлыг эсэргүүцэн гомдол гаргаж, авто замын маршрутыг өөрчлүүлсэн.	70
--	--	--	--	--	--	--	--	----

4.3. Аялал жуулчлалын салбар

25	Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, менежментийг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлнэ.	58	Аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2018 - 2020	-	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна.	-	Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэхээр 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн батлуулж төлөвлөгөөний дагуу Хаялга нуур, Нэртийн булаг, Бэхтийн булгийн орчны хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулсан. Мөн ОНХС-ийн 200000 төгрөгийн хөрөнгөөр Нэртийн булгийн хашааг сэргээн засварлах ажлыг зохион байгуулсан.	70
		59	Аяллын маршрут ын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.	2018 - 2020	ОНХС 5.0	Улсын чанартай авто зам, аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах 1 цэг байгуулсан байна.	ОНХС 5.0	Улсын чанартай авто зам дагуу түр буудаллах нэг цэгийг аймгийн орон нутгийн хөгжил сангийн 7,2 сая төгрөгийн хөрөнгөөр 2 оо, 1 хогийн сав байгуулсан.	100
		60	Түүх, соёлын өвийг сэргээж хамгаална.	2018 - 2020	ОНХС	Зуун умай хөшөө дурсгалыг сэргээн засварлаж хашаажуулна.	ОНХС 20.0	Зуун умай хөшөө дурсгалыг сэргээн засварлаж, хөшөө болон хашааг будах ажлуудыг Соёлын төвтэй хамтран 9-р сард гүйцэтгэхээр төлөвлөөд байна.	Үнэлэх боломжгүй

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

5.1. Тогтвортой, хариуцлагатай эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр

26	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	6 1	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ	2018 - 2020	ОНХС	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хангагдсан байна.	АОНХ С	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэхээр 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр батлуулсан. Уг хөтөлбөрийн эхний хагас жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 58,6 хувийн биелэлттэй байна.	40
		6 2	Төрийн албан хаагчдын авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөл, мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, чадавхижуулна.	2018 - 2020		Төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна. Мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулсан байна. Төрийн албаны туршлагыг судлан нэвтрүүлнэ.	БТ ОНХС	Аймгийн татварын хэлтсийн мэргэжилтэн Гандуламтай хамтран албан хаагчдыг “Хувь хүний хөгжил”, “Багаар ажиллах чадвар” сэдэвт төлбөртэй сургалтуудад 70 төрийн албан хаагчдыг хамруулсан. Улаанбаатар болон бусад аймаг, сумдад зохион байгуулагдсан дунд болон богино хугацааны 20 гаруй сургалтад холбогдох албан хаагчдын хамруулан томилолтын зардлыг олгон ажиллаж байна. ЗДТГ-ын 2 албан хаагчийг магистрын зэрэг хамгаалуулахаар “Орхон” их сургуульд сургаж байна.	70
27	Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэнэ.	6 3	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2018 - 2020	ОНХС	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдэд тайлагнана. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа 2 дахин багассан байна. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал авч үр дүнг үнэлнэ.	-	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эмхэтгэл болгон 50 гаруй иргэнд тарааж ажилласан. 2019 оны 06 дугаар сарын байдлаар Засаг дарга болон ЗДТГ-т нийт 223 өргөдөл ирсэнийг 15 хоногийн хугацаанд шийдвэрлэж 15 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна. 2019 оны 1, 2 дугаар улирлын өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнан аймгийн Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр 20	40

							гаруй өрхөөс санал асуулга авч ажилласан.		
5.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр									
28	Иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	6 4	Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх олон нийтийг хамарсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2018 - 2020	ОНХС 1.5	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, гамшгаас хамгаалах команд штабын сургууль, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулна.	ОНХС 0.5	Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу “Газар хөдлөлтийн дуут дохио”-гоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулж сумын 16 аж ахуйн нэгж, байгууллага, 1, 2-р багийн нийт 869 иргэн хамрагдсан. Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын дагуу нүүлгэн шилжүүлэх ажилд 56 автомашины бэлэн байдлыг хангаж ажилласан. Мөн гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, команд штабын сургуулийг 5 үе шаттайгаар амжилттай зохион байгуулсан. 2019 онд суманд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ зохион байгуулагдахтай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг сургуулийг 4-р сараас эхлэн 14 хоног тутам зохион байгуулж байна.	70
		6 5	Цэргийн болон улсын дайчилгааны даалгаврын хэрэгжилтийг сайжруулна.	2018 - 2020	ОНТ	Сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна Дайчилгааны нөөц бүрдүүлнэ. Оюутан цэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	ОНТ	Цэргийн албаны тухай хууль, Батлан хамгаалах тухай хуулиудаар гарын авлага бэлтгэж 50 иргэнд тарааж ажилласан. Энэ жил сум, багийн Засаг дарга нарт зориулсан сургалт зохион байгуулагдаагүй болно.	40

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

д/д	Зорилт	Арга хэмжээний тоо	Үүнээс			Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь	
			100 биелсэн	Хэрэгжих шатандаа				
				70%	40%			0%
1.	5	65	7	25	22	0	11	61,7

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР